

РЕДАКТОРЫН ЗУРВАС

«Дорно-Өрнө» сэтгүүлийн маань 1993 оны анхны дугаар уншигч та бүхний гарт очоод байна. Бид хуучин «Дорно дахины судлал» нэртэй гарч байсан сэтгүүлийнхээ шилдэг уламжлалыг хадгалахын хамт шинэ санаа, шинэ эрэл хайгуулаа үргэлжлүүлж байна.

Улс эх орны өөрчлөн байгуулалт, гадаад орчны асар түргэн хурдацтай өөрчлөлт хувиралттай уялдан бид «Олон улсын харилцаа» буландаа дэлхийн болон Азийн томоохон орнуудын гадаад бодлогын чиг шугам, Монгол болон гадаад ертөнцийн харилцааны тулгамдсан цаг үеийн асуудалтай та бүхнийг танилцуулж байх болно. Энэ дугаарт та бүхэн БНСУ-ын Умардын бодлогын үр дүн, цаашдын төлөвтэй танилцана. Дараачийн дугааруудад бид БНХАУ, Оросын Холбооны Улс, Япон улсын гадаад бодлогын чиглэл, концепцийг нэн түрүүнд хөндөх болно.

Энэ дугаараас эхлэн «ХХ зууны Монгол» гэсэн шинэ буланг нээж ХХ зууны Монгол улсын түүхийн зангилаа асуудлууд, 1911 он, 1921 он, 1990 оны сонголтууд, «нэг хүний дангаар ноёрхох» систем бүрэлдсэн, түүний үр дагавар, социалист байгуулалтын жилүүдэд алдсан оносон, мөн цаашдын 90-ээд оны төлөвийн тухай түүхч, дипломат, улс төр судлаачдын олон ургальч үзэл бодлыг нийтлэхээр төлөвлөж байна.

1991 оноос хөтөлж ирсэн «Азийн орнууд ба шинэтгэл» булангаа үргэлжлүүлж энэ 1993 онд бид урьд өмнө нь төдий л сайн мэддэггүй байсан Тайланд, Малайз, Индонез зэрэг АСЕАН-ы орнуудын эдийн засгийн хөгжлийн явцтай түлхүү танилцуулах зорилго тавьж байна. Мөн «Азийн дөрвөн бар» хэмээгдэх Өмнөд Солонгос, Сингапур, Гонконг, Тайванийг ч анхаарлынхаа гадна орхихгүй нь мэдээж.

Уламжлал болсон «Түүхчийн индэр», «Архивын хөмрөгөөс» буландаа манай нэрт түүхчид Б. Ширэндэв, Ц. Пунцагноров, Н. Ишжамц, Л. Жамсран нарын шинэ бүтээлийг нийтлэхээс гадна түүхийн балархай буюу зөрчилтэй үйл явдлыг тодруулах зорилгоор дотоод, гадаадын архиваас манай судлаачдын сийрүүлж авчирсан шинэ сэргэг баримт материалтай та бүхнийг танилцуулна.

Манай сэтгүүлд урьдын адил англи, япон, хятад, солонгос хэлнээс орчуулсан улс төр, эдийн засаг, түүх соёлын материал үлэмж байрыг эзлэх болно. Үүнд Тарик Али-гийн «Сталины өв», Жон Руэ-гийн «Мао Зэдун 1927-1935 онд», Эзра Фогелийн «Япон: Нэгдүгээр зэргийн орон» номны хэсгээс орчуулан толилуулна.

1993 онд «Хүмүүс» булан та бүхний сонирхлыг татах нь маргаангүй. 1993 онд Хятадын хувьсгалын удирдагч Мао Зэдуны мэндэлсний 100 жил болох юм. Мао Зэдун болон түүхэн бусад хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны тухай олон сонирхолтой материалыг та бүхэн унших болно.

Улирал бүрийн дугаартаа «Манай лавлах», «Мэдээ, мэдээлэл» буланг хөтөлж өөрийн орны гадаад харилцааны гол чухал үйл явдлын хэлхээг байнга нийтлэхээс гадна Оросын Холбооны улс, мөн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Дундад Азийн Казахстан, Кыргызстан, Узбекистан, Тажикстан, Туркменистаны тухай лавлах материалыг ойрын дугаартаа хэвлэх болно.

Уншигч та бүхэн манай «Дорно-Өрнө» сэтгүүлийг байнга захиалан уншиж бидний нийтлэлийн бодлого, чанар чансааны талаар бодол саналаа сэтгэл харамгүй хуваалцаж байна гэдэгт бат итгэж байна.

*Сэтгүүлийн эрхлэгч, дэд эрдэмтэн
Ц. Батбаяр*